



**НИЙСЛЭЛИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР**

2014 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 14/137

Улаанбаатар хот

**Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр
гүйцэтгэгч нарт үүрэг өгөх тухай**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 11 дүгээр зүйлийн 11.1.4, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дахь заалтууд, Улсын ерөнхий гүйцэтгэгчийн 2014 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 2в/1153 дугаар албан бичгээр ирүүлсэн үүргийг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөр төлөгчийн овог нэр, регистрийн дугаар, оршин суух хаягийг нягтлан шалгаж, холбогдох газруудад лавлагааг явуулж захиран зарцуулах эрхийг хязгаарлаж байх, төлбөр төлөгч бус иргэн, түүний эд хөрөнгийн эрхийг хөндөхгүй байхыг нийт шийдвэр гүйцэтгэгчид анхааруулсугай.

2. Буцаасан, дуусгавар болсон болон хэрэгсэхгүй болгосон гүйцэтгэх баримт бичигтэй холбогдуулан төлбөр төлөгч иргэний бичиг баримт, зорчих эрх, эд хөрөнгийн эрхийг хязгаарласан эсэхийг сайтар хянаж, эрх сэргээх ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр мэдээллийн санд бүртгүүлж, архивт шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосугай.

3. Шийдвэр гүйцэтгэгчийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангаж, шуурхай ажиллахыг дүүрэг хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгч нарт даалгасугай.

4. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга, /дэд хурандаа Ч.Оюунцэцэг, хошууч Ж.Нандинтуул/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ХУРАНДАА:



Э.БАТБАЯР